

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

Н.Дамдиндорж*, Э.Ундармаа**

Хураангуй: Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, эдийн засаг, хүн амын хурдацтай өсөлт, байгаль орчны бохирдол, доройтол зэрэг нь экосистемийн тэнцвэрт байдал алдагдахад хүргэж, улс орнуудын тогтвортой хөгжилд томоохон сорилт болж байна. Энэхүү судалгаанд дотоодын болон гадаадын байгаль орчны аудитын тогтолцоог харьцуулан судалж, манай орны байгаль орчны аудитын тогтолцоонд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох бөгөөд судалгаанд байгаль орчны аудитыг гүйцэтгэж байгаа мэргэжилтэн, аудит хийлгэх шаардлагатай аж ахуйн нэгжүүдийг хамруулж, өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, судалгааны үр дүнд үндэслэн тулгамдсан зарим асуудлыг сайжруулах, шийдвэрлэх санал боловсруулна.

Түлхүүр үгс: аудит, байгаль орчин, хууль, мэдлэг, ур чадвар

CURRENT SITUATION OF ENVIRONMENTAL AUDIT, FUTURE ACTIONS IN MONGOLIA

Abstract: Global warming, climate change, rapid economic and population growth, environmental pollution and degradation are leading to ecosystem imbalances and are major challenges to sustainable development. This study compares the domestic and foreign environmental audit systems and identifies the challenges facing the country's environmental audit system. The study would include experts that conducting environmental audits and companies which need to be audited and develop proposals to improve and resolve some issues based on the results of the study.

Key words: audit, environment, law, knowledge, skill

* МУИС-ийн Бизнесийн сургууль, (E-mail): damdindorj1230@gmail.com

** МУИС-ийн Бизнесийн сургууль, (E-mail): undraa2010@gmail.com

Нэг. Байгаль орчны аудитын тухай ойлголт

1980-аад оны эхээр АНУ-ын хувийн хэвшлийнхэн анхлан ашиглаж эхэлсэн бөгөөд аливаа зөрчил, доголдлыг эрт илрүүлэх, байгаль орчны үр ашигтай менежментийг хэрэгжүүлэх, байгууллагын зардлыг хэмнэх давуу талтай байдаг учир олон салбарт нэвтрүүлж эхэлжээ. Олон улсад байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөг бууруулах зорилгоор одоо байгаа хүний үйл ажиллагааг сайжруулахын тулд байгаль орчны аудитыг ашигладаг.¹ Монгол улсад байгаль орчны аудитын тухай ойлголт, түүнд аудит хийх тогтолцоо 2012 оноос бий болсон бөгөөд “Байгаль орчны аудит гэж байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, стандартын хэрэгжилтийг хянаж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх хараат бус үйл ажиллагааг хэлнэ”² гэж тодорхойлсон байдаг. Ач холбогдол тухайн аудитын зорилгоос хамаарч янз бүр байдаг бөгөөд хуулиар хүлээсэн үүргээ сайн ойлгох, байгаль орчны бодлогыг хэрэгжүүлж байгааг нотлох, эрсдлийг урьдчилан тооцох, эдийн засгийн үр ашигтай байх зэрэг тус тусын үүрэгтэй. Өөрөөр хэлбэл байгаль орчны аудит нь өнөөгийн нөхцөл байдлын хувьд сонголтоор хийгддэг зүйл биш, харин ч болзошгүй нөлөөлөл, эрсдэл, үр дагавраас сэргийлэхэд чиглэсэн, дэс дараатай, системтэйгээр хэрэгжүүлэх цогц үйл ажиллагаа юм. Тиймээс тухайн байгууллагын байгаль орчинд учруулж болох аливаа сөрөг нөлөө, хохирол, үр дагаврыг арилгах арга хэмжээ авах, компанийн экологи-эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх, байгаль орчинд болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй аргаар үйлдвэрлэл явуулахад хэрэгжүүлэгч талд туслах, тэднийг учирч болох алдагдал, хохирлоос урьдчилан сэргийлэхэд чиглэдэг бөгөөд дараах төрлүүд байдаг.³

- Нийцлийн аудит /regulatory compliance auditing /
- Гүйцэтгэлийн аудит /environmental performance auditing/
- Хариуцлагын аудит /due diligence auditing/
- Удирдлагын тогтолцооны аудит /environmental management system auditing/

Нийцлийн аудит нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтэнд хяналт хийдэг бөгөөд АНУ зэрэг зарим улсад энэ төрлийн аудит нь сайн дурынх байх ба байгууллагын дотоод хяналтыг дэмжих үүднээс аливаа зөрчил, доголдлыг эрт мэдээлсэн тохиолдолд торгууль, ялаас чөлөөлөх зэрэг урамшуулуудыг санал болгодог байна. Харин Австралид хяналтын байгууллагаас гэнэтийн байдлаар хийгддэг бол манай орны хувьд “Байгаль орчныг хамгаалах тухай” хуульд 2 жил тутам зайлшгүй аудит хийлгэхээр хуульчилсан байдаг.

Гүйцэтгэлийн аудит нь ихэвчлэн сайн дурынх байдаг бөгөөд байгууллагын сайн туршлага, дадлагын дагуу байгаль орчны гүйцэтгэлийг үнэлэхэд чиглэгддэг. Гүйцэтгэлийн аудит нь тухайн байгууллагуудад байгаль орчны сөрөг нөлөөллийг

¹ Байгаль орчин нийгмийн менежментийн систем, 2018.02.

² Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А-126.дугаар тушаалын 2 дугаар хавсралт, **Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал.**

³ НҮБ, Монгол улсын Байгаль орчны гүйцэтгэлийн цуврал үнэлгээний тайлан, №49, 2018.

бууруулах, зардлаа багасгах замаар үйл ажиллагаагаа илүү оновчтой, үр ашигтай хөтлөн явуулах боломжийг олгодог.

Тухайн байгууллагын хөрөнгүүдийн өнөөгийн болоод өмнөх үеийн байгаль орчны нөлөөллийг тодорхойлоход орших бөгөөд ихэнх тохиолдолд бизнесийн эрсдлийг багасгахын тулд зээлдүүлэгч болон хуулийн зөвлөхүүдийн саналаар хийгддэг.

Байгаль орчны аудитын гүйцэтгэх үүрэг нь иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа нь байгаль орчныг хамгаалах, хууль эрх зүй, үндэсний болон олон улсын стандартын шаардлагад хэрхэн нийцэж буйг баримтжуулж, тодорхойлох системчлэгдсэн цогц үйл ажиллагаа юм.⁴

- Тухайн байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй үйлчилгээ холбогдох хууль, эрхзүйн болон байгууллагын дотоод журамд хэрхэн нийцэж байгаа эсэх
- Байгаль орчны ажил, ажилбарт менежментийн хяналт тавьж байгаа эсэх
- Байгаль орчны менежментийн зохистой тогтолцоог бүрдүүлсэн эсэх
- Ард иргэдтэй итгэлцлийн харилцааг бий болгож чадах эсэх
- Байгууллагын байгаль орчны талаархи бодлогыг ажилчиддаа ойлгуулж, тэдгээрийн үүргийг хэрэгжүүлсэн эсэх
- Байгаль орчны үйл ажиллагааг сайжруулах боломжуудыг судласан эсэх
- Байгаль орчны менежментийн тогтолцоо бүрдүүлэх үйл ажиллагааны суурь нөхцлийг хангасан эсэх

Байгаль орчны аудитын үндсэн 4 объект байдаг ба агаар, биологийн төрөл зүйл, ус, хог хаягдал зэрэгт аудит хийнэ.⁵ Агаарын аудитын гол асуудал бол агаарын бохирдол юм. Сүүлийн үед эдийн засгийн өсөлт, үйлдвэрлэл хурдацтай хөгжиж, эрчим хүчний зарцуулалт ихсэнийн үр дүнд агаарын бохирдол өсөн нэмэгдэж байна. Биологийн төрөл зүйл гэж эх газар, далай тэнгис болон бусад усны экосистем, экологийн цогцолбор зэрэг бүх л орчинд оршин амьдардаг амьд организмуудын хоорондын олон янз байдал бөгөөд энэ зүйлүүдийн доторхи эсвэл зүйлүүд хоорондын болон экосистем хоорондын олон янз байдал буюу ургамал, амьтан, бичил организмууд, тэдгээрийн ген, тэдгээрийн оршин буй системүүд багтана. Усны алдагдал болон ус хэмнэх нөхцлийг тогтоож, түүнд шаардагдах хөрөнгийг тооцох, усны хэрэглээнд үнэлгээ хийх ажиллагааг усны аудитад хамааруулан ойлгож болох бол хог хаягдлыг ангилахдаа:

1. Аюулгүй хог хаягдал — ахуйн хог хаягдал
2. Аюултай хог хаягдал — хүн болон байгаль орчинд хор хөнөөл учруулах
3. Цацраг идэвхт хог хаягдал — цацраг идэвхт чанар агуулсан хүний амь насанд хүрэх.

Байгаль орчиндоо харшлахгүй гүйцэтгэлтэй байх нь тухайн байгууллагын зах зээлийн үнэлгээг өсгөхөөс гадна тухайн орон нутагтаа нэр хүндтэй байх бөгөөд байгаль

⁴ Европын холбооны зөвлөл, 1993. Холбооны зөвлөл №1836/93 Л 168, 10/07/93.

⁵ Д.Батболд, Байгаль орчны аудитын гарын авлага (2009)

орчны аливаа осол, эндэгдэл учрахаас өмнө илрүүлж, урьдчилан сэргийлснээр түүнээс үүдэн гарах хор хөнөөлийг бууруулж, хуулийн өр төлбөр үүсэх зардлыг хэмнэнэ.

Хоёр. Өнөөгийн байдлын судалгаа

Монгол улсад Байгаль орчны багц хууль батлагдахад Байгаль орчныг хамгаалах тухай хуульд Байгаль орчны аудитын талаар тусгасан бөгөөд энэ нь байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, стандартын хэрэгжилтийг хянаж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх хараат бус үйл ажиллагааг хэлнэ гэж заасан. 2013 оноос холбогдох дүрэм журмыг баталснаар байгалийн нөөц ашиглаж буй аж ахуйн нэгжүүд хоёр жилд нэг удаа заавал аудит хийлгэдэг байхаар хуульчилсан. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, гүйцэтгэлийг шалгаж, үнэлгээ өгөх, зөвлөмж өгөх талаасаа энэ аудит нь компанийн үйл ажиллагаанд маш үр өгөөжтэй байдаг. Тиймээс төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ дараахаас бүрдэнэ. Үүнд:

- Төрийн захиргааны төв байгууллагаас хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн
- Боловсон хүчнийг бэлтгэсэн. /4 сургалт, 164 аудитор/
- Аудитын мэргэжлийн байгууллагад эрх олгосон. /33 компани/
- Тайланг аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас авч нэгтгэн сан бүрдүүлдэг болсон
- Аудитыг Мэргэжлийн хяналтын газрын хяналтын хуудсанд оруулсан

Одоогоор манай оронд байгаль орчны аудит хийлгэхээр хуулинд заасан аж ахуй нэгж байгууллагаас 103 нь аудит хийлгэсэн бөгөөд аудит хийлгэсэн компаниудын 64% нь уул уурхай, 20% нь үйлдвэрлэл үлдсэн 16% нь аялал жуулчлалын компаниуд хамрагдаад байна.

Дэлхий дахинд тэр дундаа АНУ, Англи, Австрали зэрэг орнуудад 1980-аад оноос эхлэн байгаль орчны аудит хөгжсөн ба Австралид Байгаль орчны аудитын Үндэсний зөвлөл байгуулагдсан ба салбаруудаараа дамжуулан үйлдвэрлэл, хүний үйл ажиллагаанаас байгаль орчинд учирч болох нөлөөллийг тогтоох, үнэлэх ажлуудыг гүйцэтгэдэг. Тиймээс эдгээр улсуудад байгаль орчны аудит нь тогтвортой уул уурхайн хөгжилд хүрэх арга зам гэж үздэг. 2002 онд АНУ-ын судлаач Richard Welford байгаль орчны аудитын арга техник дээр суурилсан таван түвшинг тодорхойлсон байна. Үүнд:⁶

Хүснэгт 1. Байгаль орчны аудитын арга хэрэгсэл

Түвшин	1	2	3	4	5
Аудитын төрөл	Нийцлийн аудит	Системийн аудит	БО-ны аудит	Экологийн аудит	Тогтвортой байдлын аудит
Үнэлгээ	Статик	Статик	Статик	Динамик	Динамик

Эх сурвалж: Environmental auditing and sustainable development from the perspective of a government auditing, 2005

⁶ <https://pdfs.semanticscholar.org/ed01/922e171321c2cf01d48596ef60868730b194.pdf>

Нэгдүгээр түвшин- Аудит хийх үндсэн суурь нь хууль тогтоомж, зохицуулалт, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг үнэлэх явдал байдаг. 1990 оны эхэн үе хүртэл байгаль орчны аудитыг дагаж мөрдөх хандлага анхдагч түвшнээс доогуур байсан.

Хоёрдугаар түвшин- 1990- ээд оны дундуур үүсэхдээ анхлан ISO 14001, EMAS зэрэг олон улсын стандартуудыг нэвтрүүлсэн бөгөөд байгаль орчны менежментийн системийг тасралтгүй байлгахын тулд тогтмол шалгаж байх хэрэгцээ гарсан. Ингэснээр байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулна гэж үздэг ба системийн аудитын зорилт, зорилтуудаас үнэлгээ нь шууд хамаардаг.

Гуравдугаар түвшин- Тухайн компанийн байгаль орчны гүйцэтгэлийн талаархи мэдээллийг ихэвчлэн нэг дор, тодорхой нэг баазад төвлөрүүлэхэд чиглэсэн. Ингэснээр гарч болох үр дагавар, болзошгүй нөхцөл байдлыг төлөвлөх, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах ач холбогдолтой.

Дөрөвдүгээр түвшин- Аудитын уламжлалт арга барилаас илүү гарч эхлэх ба хэд хэдэн талаараа онцлох өөрчлөлтийг шаарддаг. Экологийн аудит нь дараах үндсэн гурван шинж чанартай байдаг. Үүнд:

1. Үнэлгээний горим нь динамик байх ёстой;
2. Амьдралын мөчлөгийн нөлөөлөлд илүү их анхаарал хандуулах хэрэгтэй;
3. Экологийн асуудлыг илүү өргөн хүрээнд шийдвэрлэх шаардлагатай.

Амьдралын мөчлөгөөр биологийн олон янз байдал, амьдрах орчин, хүн, амьтны эрх, сэргээгдэхгүй нөөц зэрэгт үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэх ёстой.

Тавдугаар түвшин- Бидний эцсийн зорилго бол аудитын цар хүрээг өргөжүүлэх бөгөөд энэ нь аудитын тогтвортой байдал руу шилжих гэсэн санааг илэрхийлнэ. Байгаль орчны аудитын тогтвортой хөгжлийн урьдчилан тодорхойлсон цогц арга боловсруулж, ач холбогдол өндөр гэсэн ойлголтод хүргэнэ. Тодруулбал, хог хаягдлыг багасгах, дахин ашиглах, дахин боловсруулах зэргээр үл сэргээгдэх нөөцийн ашиглалтыг зохицуулахад анхаарах ёстой гэсэн санааг илэрхийлнэ.

Үүнээс гадна олон улсад ISO 14001, ISO 14004, ISO 19011 зэрэг стандартууд хэрэглэгдэж байгаа бөгөөд ISO 14001 стандартын шаардлагуудыг хангасан байгаль орчны удирдлагын тогтолцоо нь бүх төрлийн байгууллагуудад дараах боломжуудыг нээж өгдөг.

- Үйлдвэрлэл, үйлчилгээ болон үйл ажиллагаандаа байгаль орчны асуудал, нөлөөллийг тодорхойлж, хянах
- Байгаль орчны гүйцэтгэлээ тасралтгүй сайжруулах
- Байгаль орчны зорилго, зорилтоо тодорхойлох, зорилго зорилтдоо хүрэх системтэй арга барилыг бий болгох

ISO 14004: Энэ нь байгаль орчны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн заавар бөгөөд байгаль орчны удирдлагын тогтолцоо нь бусад удирдлагын тогтолцооны зарчим, зохицсон байдал зэргийг хангадаг. Энэхүү заавар нь байгаль орчны удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжүүлэх, хөгжүүлэх

сонирхолтой бүх байгууллагуудад хамаарна. Энэ нь сайн дурын, дотоод удирдлагын хэрэгсэл байх зориулалттай бөгөөд ямар нэг сертификат, бүртгэлд зориулагдаагүй;

ISO 19011: Байгаль орчны аудит хийх заавар бөгөөд энэ стандарт дотор чанарын болон байгаль орчны аудитыг үр дүнтэй төлөвлөх, удирдах, үнэлэхэд зориулсан зарчмын дөрвөн шийдэл/дэмжих нөөц байгаа:

1. удирдлагын тогтолцооны аудитын зарчмыг маш тодорхой тайлбарласан
2. аудитын хөтөлбөр боловсруулах заавар
3. дотоод эсвэл гадаад аудитыг удирдах заавар
4. аудиторуудын чадвар болон үнэлгээний зөвлөгөө.

Стандартын үндэс нь аудиттай холбоотой хүн бүрт үр дүнтэй ажиллахад нь туслах зарчим бөгөөд аудитын удирдлагын одоогийн процесст чиглэгддэг учир аль ч удирдлагын түвшинд аудит хийхэд хэрэглэх боломжтой.

Улс орон бүрийн байгаль орчны аудитын бодлого харилцан адилгүй бөгөөд манай орны бодлого горимыг АНУ, Европын холбоо болон Австрали улсынхтай харьцуулбал.

Хүснэгт 2. Бодлого горимын харьцуулалт

Асуудлууд	Монгол	АНУ	Европын холбоо	Австрали
Ерөнхий зорилго	Хувийн хяналтыг дэмжих	Хувийн хяналтыг дэмжих	БО-ы сайн гүйцэтгэлийг дэмжих	БО-ны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах
Зорилгот байгууллага	Хувийн хэвшил	Хувийн хэвшил	Өргөн хүрээг хамарсан	Байгаль хамгаалах гэрчилгээтэй байгууламжууд
Олон нийтэд мэдээлэх	Тийм \ аудитын тайлан\	Тийм \эцсийн үр дүн\	Тийм \БО-ы мэдүүлэг\	Тийм \аудитын тайлан\
Сайн дурын эсвэл зайлшгүй эсэх	Зайлшгүй шаардлагатай	Сайн дурын	Сайн дурын	Зайлшгүй шаардлагатай
Аудит хийлгэх давтамж	2 жил	Тодорхой биш, ихэвчлэн 1-3 жил	1-3 жил	Тодорхой биш
Аудиторууд	Хараат бус	Хараат бус	Хараат бус	Хууль хяналтын байгууллагын ажилтан
Аудиторын мэргэшил	Мэргэжлийн зөвлөл	Гэрчилгээ олгогч ТББ	Магадлан итгэмжлэл	Гэрчилгээ олгогч ТББ \RABQSA\

Эх сурвалж: 789

⁷ АНУ: United States Environmental Protection Agency, Incentives for Self-Policing, Discovery, Disclosure, Correction and Prevention of Violations, Notice, Federal Register, Vol.65, No.70, April 2000, (<https://www.epa.gov/compliance>)

⁸ Европын холбоо: Европын холбооны Эко-менежмент аудитын тогтолцоо, (https://ec.europa.eu/info/index_en)


⁹ Австрали (New South Wales): БО-ыг хамгаалах байгууллагын хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах аудитын хөтөлбөр, (<https://www.environment.nsw.gov.au/licences-and-permits>)

Гадаад орны тогтолцооноос үзэхэд байгаль орчны аудитыг ихэвчлэн сайн дураараа эсвэл шаардлагатай тохиолдолд хийлгэдэг байна. Харин аудиторуудад тавигдах нийтлэг шаардлага нь манай улстай ижил төстэй байна. Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасны дагуу байгалийн нөөц баялаг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй ААНБ-ууд 2 жил тутамд хуваарьт аудитыг заавал хийлгэх шаардлагатай гэж заасан байдаг нь бусад оронд аудит хийлгэх давтамжтай ойролцоо болох нь харагдаж байна.

Гурав. Монголд хийгдсэн судалгааны үр дүн


2000-аад оны эхнээс дэлхийн улс орнууд үйлдвэрлэл, хэрэглээнийхээ хэв маягийг эрс өөрчилж, ногоон хөгжлийн хэв маягт шилжих болсноор Монгол улс анх 2014 онд “Ногоон хөгжлийн бодлого”-ыг батласан. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхдээ байгаль орчны аудитын үйл ажиллагаа чухал үүрэгтэй болохыг онцлосон бөгөөд манай улсын хувьд хожуу нэвтэрсэн, харьцангуй шинэ ойлголт тул зарим талаараа дутагдалтай зүйлс байгаа. Тиймээс бид 2019 оны 10, 11 дүгээр саруудад байгаль орчны аудиторуудын мэдлэг чадвар, хууль эрх зүй, стандарт, ёс зүй болон хүний нөөцийн сургалт, хөгжил гэсэн 4 чиглэлийн хүрээнд 18 асуулт бүхий асуулга боловсруулж Үндэсний аудитын газар болон Нийслэлийн аудитын газрын нийт 37 аудитор, мэргэжилтнийг судалгаанд хамруулсан. Судалгаанд хамрагдагсдын 42 хувь нь мэдлэг ур чадвар бүхий хүний нөөцийн дутмаг байдал, мөн 42 хувь нь хууль эрх зүйн орчин хангалтай бүрэлдээгүй гэж хариулсан байна.

Дүрслэл 1. Тулгамдаж буй асуудал



Аудиторуудын мэдлэг, ур чадвар дутмагаас гадна байгаль орчны аудитор цөөн байгаа бөгөөд компаниудаас асуулга авахад аудитын мэргэжлийн боловсон хүчний чадавхи сул гэсэн нь нэг талаас манай улсын хувьд энэ салбарын аудит шинээр нэвтэрч байгаа тул үйл ажиллагаа жигдэрч эхлээгүй, дадлага туршлага бага байгаатай холбоотой. Байгаль орчны аудитын эрх зүйн орчныг бүрдүүлэхэд дараах баримт бичгүүдээс аль нь хамгийн чухал вэ? гэсэн асуултанд дараах байдлаар хариулсан байна.

Дүрслэл 2. Хариултын бүтэц, тайлбар



- 36.8% нь байгаль хамгаалах хууль
- 26.3% нь холбогдох заавар журам
- 21.1% нь аудитын үндэсний стандарт
- 10.5% нь ISO 19011 стандарт
- 5.3% нь ISO 14000 гэж тус тус үзжээ.

Цаашид боловсронгуй болгож, ахиц гаргахын тулд хуваарьт байгаль орчны аудитыг уул уурхайн салбараас бусад салбаруудад шаардлагатай тохиолдолд хийдэг байх, стратегийн хувьд хөгжүүлэх, идэвхжүүлэх зорилгоор энэ салбарт хүлээн зөвшөөрөгдсөн, мэдлэгтэй экспертүүдийг аудитор болгох замаар тэдний мэдлэгийг ашиглах, хүний нөөцийг бүрдүүлэх, зарим төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд захиалгат аудит хийлгэж байгаль орчны салбарын асуудлыг сайжруулах шаардлагатай байна.

Мөн Байгаль орчны аудитын үйл ажиллагаатай холбоотой хууль, стандарт, ёс зүйн дүрэм зэргийн талаар тогтмол сургалт явуулдаг уу? гэсэн асуултанд 48% нь аудитын үйл ажиллагаатай холбоотой хууль, стандарт, ёс зүйн дүрэм зэргийн талаар тогтмол сургалт явуулдаг, 26% нь тогтмол сургалтын модуль байхгүй, 26% нь зөвхөн өөрчлөлт орсон тохиолдолд гэсэн хариултыг тус тус өгчээ.

Дүгнэлт, санал зөвлөмж:

Дээрх санал асуулгуудыг нэгтгэн дүгнэхэд байгаль орчны аудитын хууль эрх зүйн орчин бүрдээгүй, мэдлэг ур чадвар бүхий хүний нөөц дутмаг байгаа нь эн тэргүүн тулгамдаж буй асуудлууд болоод байна. Түүнчлэн, байгаль орчны аудит хийх, эрх олгох журманд “Аудит хийх хуулийн этгээд энэ аудитын чиглэлд үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлнэ” гэж заасан тул аудит хийх эрх нь харьцангуй хязгаарлагдаж, хэрэгжилт удаашралттай байгаагийн нэг шалтгаан байж болзошгүй юм.

Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуульд 2 жил тутам байгаль орчны хуваарьт аудитыг заавал хийлгэх шаардлагатай байдаг. Харин гадны улс оронд өөрийн төслийн үйл ажиллагааг байгаль орчинд ээлтэй, илүү үр ашигтай байдлаар хэрэгжүүлэхэд мэргэжлийн зөвлөгөө авах үүднээс сайн дураараа эсвэл байгаль орчны бохирдлын хэмжээ стандартаас давсан зэрэг шаардлагатай тохиолдолд хийлгэдэг байна. Манай улсын байгаль орчны аудиторт тавигдах нийтлэг шаардлага нь бусад орнуудтай ижил төстэй олон зүйл байна. Энэ бүхнээс дүгнэж үзээд дараах зүйлсийг санал болгож байна. Үүнд:

- Байгаль орчны аудитын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн хийдэг болох
- Аудитын ач холбогдлын талаар аж ахуйн нэгж, байгууллагад зориулсан сургалт, сурталчилгааг зохион байгуулах

- Урамшуулах, хөнгөлөлт үзүүлэх болон хариуцлагын тогтолцоог оновчтой тодорхойлж, хэрэгжүүлэх
- Боловсон хүчнийг бэлтгэх, сургалтын хөтөлбөрийг сайжруулж, тасралтгүй боловсролын сургалтыг тогтмолжуулах

Ашигласан материал:

А. Өгүүлэл

- [1] Амараа.Д, Уул уурхай дахь байгаль орчны аудит, УБ: SESMIM project, 2016
- [2] Анармаа.Ш, Байгаль орчны аудитын хууль эрхзүйн дүн шинжилгээ, УБ: БОАЖЯ, SESMIM project, 2017.
- [3] Баярцэцэг.С, Байгаль орчин, нөхөн сэргээлт, байгаль орчинд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт, УБ: БОНХЯ, 2017

Б. Ном, нэг сэдэвт бүтээл

- [4] Батболд.Д, Байгаль орчны аудитын гарын авлага, 2009.
- [5] Үндэсний Аудитын Газар, Байгаль орчны аудит гарын авлага, 2009.

В. Хууль, стандарт, дүрэм, журам

- [6] Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын А-126 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал, 2013.
- [7] Монгол Улсын Их Хурал, Ногоон хөгжлийн бодлого, 43 дугаар тогтоолын хавсралт, 2014.

Г. Бусад

- [8] Байгаль орчин нийгмийн менежментийн систем, 2018.
- [9] Байгаль орчныг хамгаалах байгууллагын хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах аудитын хөтөлбөр, (<https://www.environment.nsw.gov.au/licences-and-permits>)
- [10] Европын холбооны зөвлөл, Холбооны зөвлөл №1836/93 Л 168, 10/07/93, 1993.
- [11] Европын холбооны Эко-менежмент аудитын тогтолцоо, (https://ec.europa.eu/info/index_en)
- [12] НҮБ, МУ-ын тогтвортой хөгжлийн тайлан, 2018.
- [13] НҮБ-ын ЕЭЗК, МУ-ын Байгаль орчны гүйцэтгэлийн цуврал үнэлгээний тайлан, №49, 2018.
- [14] United States Environmental Protection Agency, Incentives for Self-Policing, Discovery, Disclosure, Correction and Prevention of Violations, Notice, Federal Register, Vol.65, No.70, April 2000, (<https://www.epa.gov/compliance>)